



МОНГОЛ УЛС
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРОО

Засгийн газрын VIII байр, Олимпийн гудамж 2,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976-51) 26 38 46

Цахим шуудан: ethics@moh.gov.mn

Цахим хуудас: <http://ethics.mohs.mn>

2025. 10. 23 № 25/137

танай -ны № -т

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН
ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН
ТӨВ, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР,
НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, БҮСИЙН
ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Аяны удирдамж хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/402 дугаар тушаалаар баталсан “Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлье” аяныг эрүүл мэндийн байгууллага бүр 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаатай зохион байгуулж, ёс зүйг дээдэлсэн хамт олныг бүрдүүлэн, хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт: 6. хуудастай.

ДАРГА



Д.ОЮУНБИЛЭГ



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/402

Улаанбаатар хот

Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.3.12 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 64 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/331 дүгээр тушаалаар батлагдсан арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулах "Ёс зүйн зөрчлийг үл тэвчье" аяны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Аяныг 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаатай зохион байгуулах ажлыг Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. "Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлье" аяныг үнэлэн, шалгарсан тасаг, нэгж, ажилтанд олгох урамшууллыг эрүүл мэндийн байгууллага батлагдсан төсөвтөө багтаан олгохыг дарга, захирал нарт даалгасугай.

4. Аяны зохион байгуулалт, хэрэгжилтэд хяналт тавин, үр дүнг тайлагнахыг Бодлого төлөвлөлтийн газар, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд тус тус даалгасугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН

141252065

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10
дугаар сарын 20 -ны өдрийн А/402
дугаар тушаалын хавсралт

**“ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙГ ҮЛ ТЭВЧИХ СЭТГЭЛГЭЭГ ХЭВШҮҮЛБЭ”
АЯНЫ УДИРДАМЖ**

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2025”-д засаглалын хувьд чадварлаг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх, чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх урт хугацааны зорилт тавин улмаар төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоо бүрдэж, ёс зүйтэй төрийн алба төлөвшинө хэмээн хүрэх үр дүнгээ тодорхойлсон байна. Энэхүү зорилтыг биелүүлэх, үр дүнд хүрэхийн тулд 2024-2030 онд хэрэгжих дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөр болох төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.3-д “Төрийн албаны шинэчлэл хийгдэнэ”, 4.2.3.12. “Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулж, ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ” 4.2.3.13. “Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршлагад суурилан хэрэгжүүлнэ” хэмээн тусгасан.

Монгол Улсын Ерөнхий сайд төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах, залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулах зорилгоор 4 удаагийн албан даалгавар гаргаж, үүрэг чиглэл өгсөн.

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо нь сүүлийн 5 жилийн байдлаар 600 орчим өргөдөл, гомдлыг эрүүл мэндийн ажилтан, иргэдээс хүлээн авч, хянан шийдвэрлэсэн байна. Тус хороонд ирж байгаа өргөдөл, гомдлын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд 3 өргөдөл тутмын 1 нь удирдах ажилтны ёс зүйтэй холбоотой өргөдөл байсан бол 2024 оны байдлаар 2 өргөдөл тутмын 1 нь удирдах ажилтны ёс зүй, харилцаа, хөдөлмөрийн харилцааны зохицуулалттай холбоотой байгаа нь удирдах ажилтны сонгон шалгаруулалт, томилгоонд ёс зүйн хэм хэмжээний асуудлыг онцгойлон анхаарах шаардлагатайг илэрхийлж байна.

Иймд дээрх бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, чадварлаг, ёс зүйтэй эрүүл мэндийн байгууллагын соёлыг хэвшүүлэхэд анхаарч, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд болон удирдах түвшний менежерүүдэд ажлын байрны сургалтыг тасралтгүй зохион байгуулах, эрүүл мэндийн салбарын хэмжээнд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

ХОЁР. ЗОРИЛГО

Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн эрүүл мэндийн байгууллагын соёлыг хэвшүүлэх замаар иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад оршино.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүр хамрагдана.

ДӨРӨВ. ХУГАЦАА

2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 12 дугаар сарын 23-ны өдөр хүртэл 2 сарын хугацаатай зохион байгуулна.

ТАВ. САНХҮҮЖИЛТ

Байгууллагын дотоод төсөв, хамтын ажиллагааны хүрээнд санхүүжүүлнэ. Шалгарсан тасаг, нэгж, эрүүл мэндийн ажилтнуудад тухайн байгууллага урамшууллыг олгоно.

ЗУРГАА. АЯНЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эерэг харилцаа, хандлагыг төлөвшүүлэх, байгууллагын соёлыг бүрдүүлэх чиглэлээр:

- Тасаг, нэгжүүд уриа, зорилготой болох
- “Ёс зүйгээр манлайлагч” эрүүл мэндийн ажилтныг шалгаруулж, хамт олны соёлыг бүрдүүлэх
- Ажлын байрны хувцаслалт, биеэ авч явах хэм хэмжээг төлөвшүүлэх
- Ёс зүйн зөрчлийн үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлэх чиглэлээр зөв жишиг харуулсан шторк, рийлс, контент хийх
- Эрүүл мэндийн ажилтны өөрийн, удирдлагын, багийн болон үйлчлүүлэгчийн үнэлгээ зохион байгуулах
- Шинэ санаа, санаачлага гаргасан байх

Сургалтын чиглэлээр:

- Ажлын байрны сургалт зохион байгуулах (сургалтын хөтөлбөрийн агуулгад ёс зүйн талаарх хууль, дүрэм, журмыг сурталчлах, ёс зүйн зөрчлийн үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлэх, хувь хүний хөгжил, манлайлал, мэргэжлийн үнэ цэн, хариуцлагын чиглэлээр тусгах)
- Иргэдийг соён гэгээрүүлэх

Сурталчилгаа, мэдээлэл:

- Ёс зүйн буланг хүлээлгийн танхим, сувилагчийн пост, ажилчдын амрах хэсэг гэх мэт нийтэд нээлттэй, хандалттай байрлалд байршуулах сурталчилгаа хийх
- Самбар (дотоод болон гадаад хандалттай) байршуулж сурталчилгаа хийх
 - Гадаад самбар (иргэдэд)
 - Үйлчлүүлэгчийн эрх, үүргийн талаарх мэдээлэл
 - Ёс зүйтэй, соёлтой, хүндэтгэлтэй харилцах зөвлөмж
 - Зөрчил гарсан тохиолдолд хандах боломжууд (утас, QR код, и-мэйл)
 - Дотоод самбар (ажилтнуудад)
 - Ёс зүйн зөрчилд анхаарах 5 дохио (шинж тэмдэг)
 - Ёс зүйн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд
 - Сургалт, хэлэлцүүлгийн хуваарь, аяны зар, төлөвлөгөө
- Сошиал мэдээллийн хэрэгслээр (Facebook, Instagram, TikTok, YouTube, Telegram гэх мэт) сурталчилгаа хийх
 - Постын төрөл:
 - Цуврал пост: “Ёс зүй өдөр тутамд” (түүхэн кейс, зөвлөгөө, эшлэл)
 - Инфографик: Ёс зүйн хэм хэмжээ, үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, харилцааны зөвлөгөө
 - Видео: Үлгэрлэгч эмч/сувилагчийн яриа, туршлага хуваалцах богино бичлэг

- Хаштаг: #ёсзүйнзөрчлийгүлтэвчихсэтгэлгээгхэвшүүлье
- QR кодтой холбоосууд:
 - Ёс зүйн хэм хэмжээг татаж авах
 - Санал, гомдол илгээх форм
 - Сургалтын бичлэгүүд
- Эмнэлгээр үйлчлүүлэгч, иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх мэдээллийг түгээх

ДОЛОО. ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ БҮТЭЦ

Зохион байгуулах нэгж	Үүрэг
Аяныг зохион байгуулах комисс	Аяныг удирдан чиглүүлэх, төлөвлөгөө гаргах, батлуулах, санхүүжүүлэх, тайлагнах
Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо, салбар, хэсгийн хороо, баг	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих
Сургалтын баг	Сургалт зохион байгуулах, үнэлгээ хийх
Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж	Сургалт, урамшууллын зохион байгуулалт

НАЙМ. АЖИЛТНЫГ ҮНЭЛЭХ

- Байгууллагын тасаг нэгж нь эрүүл мэндийн ажилтны хандлага харилцааг үнэлгээний хуудас боловсруулан үнэлж дүгнэнэ.
- Байгууллагын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг 14 хоногт нэг удаа явцын үнэлгээ хийнэ.
- Үнэлгээг хийхдээ өөрийн, шууд харьяалан удирдах ажилтны, хамт олны болон үйлчлүүлэгчийн үнэлгээг харгалзан үзнэ.
- Үнэлгээгээр 100 хувь үнэлэгдсэн ажилтанд хандлагын нэмэгдэл олгоно.

ЕС. ТАСАГ, НЭГЖИЙГ ҮНЭЛЭХ

Ажлын хэсэг нь аяны хүрээнд дараах үнэлгээг хийнэ.

- Тасаг нэгжийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэнэ.
- Сэтгэл ханамжийн судалгааг аян эхлэхийн өмнө болон хэрэгжиж дууссаны дараа авч, үр дүнг харьцуулан үнэлнэ.
- Үнэлгээнд дараах шалгуурыг ашиглана.

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур	Оноо
<i>Төлөвлөлт, тайлагналтын чиглэлээр</i>			
1	Аяны удирдамжийн дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	Батлагдсан төлөвлөгөө	5
2	Аяны үр дүнг тайлагнах, товлосон хугацаанд хүргүүлэх	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудыг зургаар баталгаажуулж, тодорхой тайлагнах	5
<i>Эерэг харилцаа, хандлагын төлөвшүүлэх, байгууллагын соёлыг бүрдүүлэх чиглэлээр</i>			

3	Тасаг, нэгж бүр уриа, зорилгоо тодорхойлсон байх	Нийтэд нээлттэй байршуулах, ажилтан бүр мэддэг байх	10
4	Ажлын хувцсыг бүрэн өмсөх, энгэрийн тэмдэг зүүж хэвших	Ажлын хувцсыг бүрэн өмсөх, энгэрийн тэмдэг зүүж хэвших /Ажлын хэсэг ажлын байран дээр очиж үнэлэх/	5
5	Мэндлэлт, харилцаа, биеэ авч явж буй соёл	Ажлын байран дээр ажлын хэсэг очиж үнэлэх	10
6	Харилцаа, хандлагатай холбоотой гомдол гараагүй байх	Ёс зүйн салбар, хэсгийн хороонд тасаг, нэгжтэй холбоотой гомдол гараагүй байх	5
7	Шторк, рийлс, контент хийх	Шторк, рийлс, контентын тоо	10
8	Эрүүл мэндийн ажилтны өөрийн, удирдлагын, багийн болон үйлчлүүлэгчийн үнэлгээг зохион байгуулах	Үнэлгээний үр дүнг тооцсон байх	10
9	Шинэ санаа, санаачлага гаргасан байх	Шинэ санаа, санаачлага гарган ажлын тоо	10
<i>Сургалтын чиглэлээр</i>			
10	Ажлын байрны сургалт зохион байгуулах	Сургалтын чиглэл, хамрагдсан хүний тоо, сургалтын үр дүнг тооцсон байх	10
11	Үйлчлүүлэгч, иргэдийг соён гэгээрүүлэх	Сургалтын чиглэл, хамрагдсан хүний тоо, сургалтын үр дүнг тооцсон байх	10
<i>Сурталчилгаа, мэдээллийн чиглэлээр</i>			
12	Ёс зүйн талаарх хууль, дүрэм журам, хийсэн ажлуудыг мэдээллийн сувгаар сурталчлах	Ёс зүйн булантай болсон эсэх, мэдээллийг цацсан суваг, нийтэлсэн мэдээлэл болон хандалтын тоо	10
Нийт			100 оноо

Аяны хүрээнд төлөвлөсөн ажлын гүйцэтгэлд тухайн байгууллагын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, хэсгийн хороо хяналт тавьж, дүгнэнэ.

АРАВ. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

- Аяны шалгуур үзүүлэлтэд үндэслэн эхний гурван байрыг шалгаруулна.
- Шалгарсан тасаг, нэгж, ажилтанд эрүүл мэндийн байгууллага батлагдсан төсөвтөө багтаан урамшуулал олгоно.

АРВАН НЭГ. ҮР ДҮН:

- Эрүүл мэндийн ажилтнуудын ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлнэ.
- Өдөр бүхэн эерэг харилцаа, хандлага, инээмсэглэлийг бусдад түгээж, ёс зүй, эв эе, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн эрүүл мэндийн байгууллагын соёлыг хэвшүүлнэ.
- Эрүүл мэндийн ажилтан бүр хамт олноо эерэгээр үлгэрлэж, эмнэлгийн мэргэжилтэн өөр хоорондын, эмнэлгийн мэргэжилтэн-үйлчлүүлэгч хоорондын харилцаа сайжирч, ажлын үр дүн, үнэлэмж дээшилнэ.
- Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, иргэд хоорондын итгэлцэл, хүндлэл бий болж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

АРВАН ХОЁР. ТАЙЛАГНАЛТ

- Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага аяны хэрэгжилтийн тайланг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.
- Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэшлийн төв, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар нэгтгэсэн тайланг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн дотор хүргүүлнэ.

ooOOOoo